

ЭРДСИЙН БАЯЛАГ, ХҮДРИЙН НӨӨЦИЙН АНГИЛЛЫН АСУУДАЛД

Б. ОЮУНЧИМЭГ

ШУТИС. Геологи, Газрын тосны сургууль


Уул уурхайн салбар өндөр хөгжсөн улс орон, түүнчлэн олон улсын байгууллагад хэрэглэж буй эрдсийн баялаг, нөөцийн тайлан гаргаж нийтэд мэдээлэх стандартыг үндсэнд нь гурав ангилж болно. Үүнд:

1. АНУ-ын Үнэт цаас, Хөрөнгийн зах зээлийн Комиссын “Аж үйлдвэрийн удирдамж 7” хэмээх баримт бичиг;
2. Австралийн Уул уурхай, Төмөрлөг боловсруулах аж үйлдвэрийн Хүрээлэн, Австралийн Геологийн шинжлэх ухааны ажилтны Хүрээлэн болон Австралийн Эрдсийн Зөвлөлийн хамтран байгуулсан Хүдрийн Нөөцийн Хамтарсан Хороо (JORC)-ноос гаргасан журам (JORC code) болон бусад орны түүнтэй адил төстэй дүрэм, журам;
3. НҮБ-ын Европын Эдийн засгийн Комисс (UN-ECE)-ын Хүрээ тогтоосон ангилал.

НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комисс (UN-ECE)-ын Хүрээ тогтоосон ангилал нь хувийн хэвшлээс гадна төрийн өмчийн хэвшил болон Засгийн газруудын эрэлт хэрэгцээг хангах өргөн цар хүрээтэй юм. Энэхүү ангиллыг төвлөрсөн болон төвлөрсөн бус эдийн засагтай улсуудад аль алинд нь хэрэглэж болохоор боловсруулж гаргажээ.

Дэлхийн олон улсад үндсэн зарчмуудыг нь хэрэглэх болж буй, Австралийн Уул уурхай, Төмөрлөг боловсруулах аж үйлдвэрийн Хүрээлэн, Австралийн Геологийн шинжлэх ухааны ажилтны Хүрээлэн болон Австралийн Эрдсийн Зөвлөлийн хамтран байгуулсан Хүдрийн Нөөцийн Хамтарсан Хороо (JORC)-ноос гаргасан “Хайгуулын ажлын үр дүн, эрдсийн баялаг, хүдрийн нөөцийн тайлан гаргах Австралийн журам”-д зааснаар эрдсийн баялаг нь геологийн баримт мэдээллийн үнэмшлийн түвшин нэмэгдэх хэрээр байж болох, урьдчилан үнэлсэн, хэмжиж тогтоосон гэсэн гурван категоритой байна. Харин хүдрийн нөөцийг баттай, бодитой гэж хоёр хуваажээ. Хүдрийн нөөц нь хэмжиж тогтоосон, эсвэл урьдчилан үнэлсэн баялагийн эдийн засгийн хувьд олборлох боломжтой хэсэг юм.

Энэхүү журамд оруулсан дараахи зураг дээр эрдсийн баялаг болон хүдрийн нөөц хоорондын харилцан хамаарал буюу ялгааг тодорхой харуулсан байна.




Зураг 1. Эрдсийн баялаг болон хүдрийн нөөц хоорондын харилцан хамаарал буюу ялгаа

Эрдэс тухий эдийн байж болох баялаг гэж биетийн хэмжээ, ашигт компонентийн агуулга болон эрдсийн найрлага нь үнэмшил багатайгаар үнэлэгдсэн эрдсийн баялагийн нэг хэсгийг хэлдэг бол урьдчилан үнэлсэн баялаг гэж хэмжээ, нягтрал, хэлбэр дүрс, физик шинж, агуулга, эрдсийн найрлага нь үнэмшихүйц түвшинд үнэлэгдсэн эрдсийн баялагийн нэг хэсгийг хэлдэг байна. Харин хэмжиж тогтоосон баялаг гэдэгт хэмжээ, нягтрал, хэлбэр дүрс, физик шинж, агуулга, эрдсийн найрлага нь ихээхэн үнэмшилтэй үнэлэгдсэн эрдсийн баялагийн тодорхой хэсгийг хамааруулдаг.

С.Авирмэд, Ж.Цэнд-Аюуш, Д.Бат-Эрдэнэ, Г.Дэжидмаа, Ж.Бямбаа, Г.Ухнаа зэрэг эрдэмтэн, судлаачдын эрдсийн баялаг, хүдрийн нөөцийн тайлан гаргах, мэдээлэх асуудлаар хийсэн судалгаа, бүтээлүүд нь ашигт малтмалын нөөц, баялагийн үндэсний ангиллыг зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн нөхцөлд нийцүүлэн боловсруулж гаргах гол үндэс болжээ.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн нөхцөлд манай улсад 1998 оноос хойш дагаж мөрдөж буй хатуу ашигт малтмалын ордын нөөц, баялагийн ангиллын бүдүүвчийг дараах зураг дээр харуулав.

Монгол Улсын ашигт малтмалын нөөц баялагийн ангилал



Зураг 2. Монгол Улсын хатуу ашигт малтмалын ордын нөөц, баялагийн ангиллын бүдүүвч.

Одоо энэхүү ангиллыг уул уурхайн салбар өндөр хөгжсөн голлох улсуудын ба олон улсын стандартын ангилалтай харьцуулж (хүснэгт-1) дүгнэлт хийе.

Манай улсын геологи, уул уурхайн салбар 1998 он хүртэл ЗХУ-ын “Хатуу ашигт малтмалын ордын нөөц ба таамаг баялагийн ангилал”-ыг мөрдөж байсан. Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газар (хуучин нэрээр)-ын даргын 1998 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 27 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын нөөц, баялагийн ангиллын түр заавар”-ын дагуу эдүгээ мөрдөж буй ангилал нь ОХУ-д ашиглаж буй эрдсийн баялаг, нөөцийн ангилалтай адил төстэй байна. Дээрхи харьцуулалтаас үзэхэд эрдсийн баялагийг олон улсын түвшинд үндсэндээ гурван категориор ангилдаг бол манайд хоёр, харин хүдрийн нөөцийг олон улсын түвшинд үндсэндээ хоёр ангилдаг бол манайд гурван категориор ангилдаг гол ялгаа харагдаж байна.

Манай улсад эрдсийн баялагийг зөвхөн хоёр категориор ангилснаас геологийн хайгуулын болон ашиглалтын үе шатны эрдсийн баялагийн тухай ойлголт орхигдсон байна.

Ийм учраас эрдсийн баялаг, нөөцийн тайлан гаргаж нийтэд мэдээлэх асуудлыг зохицуулсан түр журмыг байнгын болгож шинэчлэн гаргах, бусад улсуудыхтай харьцуулж болохуйц ангилал боловсруулахад илүү анхаарах шаардлагатай гэж үзнэ.

Дүгнэлт

Зохиогч нь геологи, уул уурхайн салбар өндөр хөгжсөн улс орон, түүнчлэн олон улсын байгууллагад хэрэглэж буй эрдсийн баялаг, нөөцийн тайлан гаргаж нийтэд мэдээлэх стандартуудад тусгагдсан эрдсийн баялаг, нөөцийн ангиллуудыг Монгол Улсад хэрэглэж буй ангилалтай харьцуулж гаргасан дүгнэлтдээ тулгуурлан эрдсийн баялаг, нөөцийн тайлан гаргаж нийтэд мэдээлэх асуудлыг зохицуулсан түр журмыг байнгын болгож шинэчлэн гаргах, бусад улсуудыхтай харьцуулж болохуйц ангилал боловсруулахад илүү анхаарах шаардлагатай гэсэн санал дэвшүүлсэн.

Ашигласан материал

- Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газар (хуучин нэрээр)-ын даргын 1998 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 27 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын нөөц, баялгийн ангиллын түр заавар”
- Австралийн Уул уурхай, Төмөрлөг боловсруулах аж үйлдвэрийн Хүрээлэн, Австралийн Геологийн шинжлэх ухааны ажилтны Хүрээлэн болон Австралийн Эрдсийн Зөвлөлийн хамтран байгуулсан Хүдрийн Нөөцийн Хамтарсан Хороо (JORC)-ноос гаргасан “Хайгуулын ажлын үр дүн, эрдсийн баялаг, хүдрийн нөөцийн тайлан гаргах Австралийн журам”
- Канадын Үнэт Цаасны Зохицуулагчдын баталсан “Үндэсний зааварлах бичиг 43-101”-гээр хүлээн зөвшөөрсөн Канадын Уул уурхай, Төмөрлөг боловсруулах аж үйлдвэр, Газрын тосны Хүрээлэн (СІМ)-гийн Зөвлөлийн “Эрдсийн баялаг, нөөцийн тодорхойлолт, удирдамжийн тухай СІМ стандарт”-д тусгагдсан ангилал
- АНУ-ын Уул Уурхайн Товчооноос баталсан ангилал
- ОХУ-ын “Хатуу ашигт малтмалын ордын нөөц болон таамагласан баялагийн ангилал”
- НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комисс (UN-ECE)-ын Хүрээ тогтоосон ангилал.

Эрдсийн баялаг, нөөцийн ангиллын харьцуулалт

Хүснэгт-1

Ангилал	Монгол Улсын Алшигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газрын багалсан ангилал	Австралийн "Хайгуулын ажлын үр дүн, эрдсийн баялаг, хүдрийн нөөцийн тайлан гаргах журам" JORC Code	АНУ-ын Уул Уурхайн Товчооноос багалсан ангилал	Канадын Үнэг Цаасны Зохицуулагчдын багалсан "Үндэсний зааварлах бичиг 43-101" CIM Code	ОХУ-ын "Хатуу ашигт малтмалын ордын нөөц болон таамагласан баялагийн ангилал"	НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комисс (UN-ЕСЕ)-ын Хүрээ тогтоосон ангилал
Эрдсийн нөөц	Багтай нөөц (хэмжиж тогтоосон), А	Ордын багтай нөөц	Ордын багтай нөөц	Ордын багтай нөөц	"А" категорийн нөөц	Ордын багтай нөөц
	Бодитой нөөц, (найлвартай магадлалтай) В	Ордын бодитой нөөц	Ордын бодитой нөөц	Ордын бодитой нөөц	"В" категорийн нөөц	Ордын бодитой нөөц
	Боломжтой нөөц, (байж болох)	-	-	-	C ₁ , C ₂ Категорийн нөөц	-
Эрдсийн баялаг	Урьдчилан үнэлсэн баялаг, P ₁	Эрдсийн хэмжсэн баялаг	Эрдсийн хэмжсэн баялаг	Эрдсийн хэмжсэн баялаг	Таамагласан баялаг P ₁	Эрдсийн хэмжсэн баялаг Эрдсийн нарийвчлан үнэлсэн баялаг
	Таамагласан баялаг, P ₂	Эрдсийн магадлалтай баялаг	Эрдсийн магадлалтай баялаг	Эрдсийн магадлалтай баялаг	Таамагласан баялаг P ₂ , P ₃	Эрдсийн магадлалтай баялаг Эрдсийн урьдчилан үнэлсэн баялаг
	-	Эрдсийн байж болох баялаг	Эрдсийн байж болох баялаг	Эрдсийн байж болох баялаг	-	Эрдсийн байж болох баялаг
	-	Тодорхой район дахь таамаг баялаг	-	Тодорхой район дахь таамаг баялаг	-	Эрдсийн таамаг баялаг
	-	Шинэ районд онолын хувьд байж болох баялаг	-	Шинэ районд онолын хувьд байж болох баялаг	-	-